

“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ”

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Үндэсний аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт
- ✓ **Зорилго:** Хичээлийн зорилго нь үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт, онолын үзэл баримтлал, төрийн бодлогын талаар сонсогчдод системтэй мэдлэг олгох, үндэсний аюулгүй байдалтай холбогдох олон улсын түвшинд тавигдаж буй гадаад, дотоод бодлого, улс төр, эдийн засаг, нийгмийн болон байгаль орчны асуудлуудыг системтэй танилцуулах, хичээлийн явцад олсон мэдлэг, мэдээллээ улс орныхоо өнөөгийн нөхцөл байдал, практик үйл ажиллагаатай холбон дүн шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, өөрсдийн шийдлийг боловсруулах ур чадварыг эзэмшүүлэхэд оршино.

- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид

- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Үндэсний аюулгүй байдлын онол, үзэл баримтлал,

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц

Сэдэв 2. Монгол төрөөс гадаад дотоод бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, мэдээлэл, соёл иргэншил, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангах зарчим, арга хэрэгслийн тухай

Ногдох цаг: 6 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага/кейс, жишээ
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Дараах хичээлүүдтэй уялдсан байх ёстой. Үүнд:
 - Монгол Улсын төрийн бодлого, түүхэн уламжлал
 - Улс төрийн манлайлал,
 - Гадаад харилцаа дипломат ёс,
 - ИТХ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалт

“ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Орон нутгийн эдийн засгийн төлөвлөлт”
- ✓ **Зорилго:** Орон нутгийн эдийн засгийн онцлогт тулгуурлан эдийн засгийн хөгжлөө төлөвлөх онолын болон практик мэдлэгийг танилцуулж, төлөвлөлт хийхэд шаардлагатай нөхцөл байдлын шинжилгээ, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээний матрицуудыг ашиглахад суралцана.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, нарийн бичгийн дарга, хурлын ажлын албаны албан хаагчид, ИТХ-ын орон нутгийн хөгжил, стратеги төлөвлөлтийн хороо, ажлын хэсэг
- ✓ **Агуулга:** Ерөнхий болон дэд сэдэв бүрийн товч тодорхойлолт, агуулга, ноогдох цаг, заах хэлбэр

Сэдэв 1. Орон нутгийн эдийн засгийн онцлог, нөлөөлөгч хүчин зүйлс

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Орон нутгийн эдийн засгийн онцлог, хөгжлийн талаарх онолын болон олон улсын байгууллагуудын дэвшүүлсэн ойлголт, мэдлэгийг танилцуулна. Түүнчлэн, эдийн засгийн суурь ойлголтыг товч хүргэж, эдийн засгаа хөгжүүлэхийн тулд ямар хүчин зүйлсийг харгалзаж үзэх учиртай талаар ярилцана.

Сэдэв 2. Эдийн засгийн нөхцөл байдлын шинжилгээ

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, багийн ажиллагаа

Сэдвийн агуулга: Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөлтийг хийхийн тулд юуны өмнө одоо хаана байгааг тодорхойлох шаардлагатай буюу нөхцөл байдлын шинжилгээ хийнэ. Өмнө үзсэн бодлого төлөвлөлт, стратеги төлөвлөлтийн сургалтуудад суурилан сонгосон аймаг, сумын жишээн дээр багууд эдийн засгийн хувьд ямар байгааг оношилж, шинжилгээний үр дүнгээ ярилцана.

Сэдэв 3. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан тухайн орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх зорилгоо тодорхойлж, стратеги төлөвлөлтийн ямар алхамуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар танилцуулахын зэрэгцээ оролцогчид хоорондоо туршлага солилцоно.

Сэдэв 4. Төлөвлөлтийг хэрэгжүүлэх арга хэрэгслүүд, тэдгээрийн үр дүнг үнэлэх нь

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, багийн ажиллагаа

Сэдвийн агуулга: Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ ашиглах бодлогын болон хэрэгжилтийн арга хэрэгсэл, механзмын талаар товч танилцуулахын зэрэгцээ төлөвлөлтийн хэрэгжилт үр дүнтэй болсон эсэхийг оролцогч талуудад таниулах хяналт, шинжилгээ үнэлгээний талаар багийн ажил явуулж, бусаддаа танилцуулна.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг (Суурь ойлголтыг өгөхөд 8 цаг болно. Захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ахисан түвшний 8 цагийн сургалт цаашид байж болно)
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага, багаар ажиллах кейс дасгал
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Тухайн хөтөлбөрийг судлахын өмнө “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”, “Орон нутгийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Орон нутгийн салбар хоорондын бодлогын зохицуулалт” сургалтуудыг заавал судалсан байх шаардлагатай. Энэхүү сургалтыг ахисан түвшинд гүнзгийрүүлэн судлах боломжтой.

**“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАХ АРГА ЗҮЙ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг хянах арга зүй
- ✓ **Зорилго:** Суралцагчид орон нутгийн төсвийн үйл явцын үе шат бүрт төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлд ИТХ-аас хяналт тавих онол, арга зүйн мэдлэгээ бататгаж, Шилэн дансны цахим хуудасны мэдээлэлд тулгуурлан төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд шинжилгээ хийх, дүгнэлт, санал боловсруулах ур чадвар эзэмшинэ.
- ✓ **Зорилгот бүлэг:** ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, нарийн бичгийн дарга, хурлын ажлын албаны албан хаагчид, ИТХ-ын Төсөв, санхүүгийн ажлын хороо, ажлын хэсгийн гишүүд, эмэгтэй төлөөлөгчид, анх болон давтан сонгогдсон төлөөлөгчид, залуу төлөөлөгчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Орон нутгийн төсөв, төсвийн орлогын эх үүсвэр, зарлагын ангилал, орон нутгийн төсвийн үйл явц, төсвийн гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд (Төсвийн зарлагын үр өгөөж: хэмнэлт, үр ашиг, үр дүн)

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц

Сэдвийн агуулга: Орон нутгийн төсөв, төсвийн орлогын эх үүсвэр, зарлагын ангилал, Орон нутгийн төсвийн үйл явцын үндсэн үе шатуудын онцлог, Төсвийн гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд - Төсвийн зарлагын үр өгөөж: хэмнэлт, үр ашиг, үр дүн

Сэдэв 2. Орон нутгийн төсвийг ИТХ-аас хянах арга, хэлбэрүүд

Ногдох цаг: 1 цаг

Хэлбэр: Багшийн лекц

Сэдвийн агуулга: Төсвийн хяналтын зорилго, төрөл, хэлбэр, ИТХ-аас тавих хяналтын арга, хэлбэр, ИТХ-аас хяналт тавихад ашиглаж болох мэдээлэл

Сэдэв 3. Орон нутгийн төсвийн ил тод байдалд хяналт тавих арга зүй

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц

Сэдвийн агуулга: Шилэн дансны цахим хуудсанд нэвтэрч төсвийн мэдээлэлтэй танилцах нь, Төсвийн ил тод байдлыг хянах, мэдээлэл хоорондын уялдааг шалгах арга зүй

Сэдэв 4. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг шинжилж, хянах арга зүй

Ногдох цаг: 3 цаг

Хэлбэр: Багшийн лекц

Сэдвийн агуулга: Төсвийн орлогын гүйцэтгэлд шинжилгээ хийж, санал боловсруулах арга зүй, Төсвийн зарлагын гүйцэтгэлд шинжилгээ хийж, дүгнэлт өгөх арга зүй

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан түвшний сургалт
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, семинар, ярилцлага, мэтгэлцээн, кейс дасгал ажиллах, багаар ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Дараах хөтөлбөрүүдийг өмнө нь судалсан байвал давуу талтай, эсвэл зэрэгцүүлэн, мөн дараа нь гүнзгийрүүлэн судлах боломжтой:
 - Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага
 - Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт
 - Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй
 - Орон нутгийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй
 - Өгөгдөл мэдээллийг орон нутгийн төлөвлөлтөд ашиглах арга зүй

**“ОРОН НУТГИЙН БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ - I”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй - I”
- ✓ **Зорилго:** Орон нутгийн бодлого боловсруулалтын чанарт дүн шинжилгээ хийх болон бодлого төлөвлөлтөөр дамжуулан нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх чадварыг дээшлүүлж, төлөөлөгчдийн бодлого боловсруулалтын талаарх ойлголтын түвшинг ижил болгох нь энэхүү хичээлийн зорилго оршиж байна.
- ✓ **Зорилтот бүлэг:** Шинээр сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч, Хурлын ажлын албаны ажилтнуудад аймаг, сумын бодлогын баримт бичгийг ИТХ-аар батлахаас өмнө
- ✓ **Агуулга:** Аймгийн болон Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахаас өмнө бодлогын баримт бичгийн боловсруулалтын чанарт түргэвчилсэн задлан шинжилгээ /анализ/ хийх, үнэлж, дүгнэх, бодлого боловсруулалтын чанарыг сайжруулах замаар орон нутгийн хөгжлийг удирдах боломжийг ашиглах чадварыг дээшлүүлнэ.

Сэдэв 1. Өмнөх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилт тэдгээрийн биелэлт, үр дүнгийн танилцуулга

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, ярилцлага

Сэдвийн агуулга: Төрийн бодлогын залгамж холбоог хангах, сургамж авах үүднээс орон нутагт хэрэгжсэн өмнөх бодлогын зорилго, зорилтын биелэлт, үр дүнг танилцуулах, харилцан санал солилцох, бодлогод үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн асуудлыг олж харахыг зорино.

Сэдэв 2. Бодлогын зорилго, зорилтыг тодорхойлох арга зүй

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Бодлогын зорилго, зорилтын шинж чанар, хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд туссан шаардлага болон батлагдсан зорилго, зорилтын томъёоллын ялгааны тухай өгүүлнэ.

Сэдэв 3. Үйл ажиллагаа ба арга хэмжээ, зорилго зорилтын ялгаа

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Өмнөх бодлогын зорилго, зорилт болон үйл ажиллагааны шинжийг харьцуулан ялгааг нь тодорхойлж, цаашид анхаарах зүйлүүдийг тунгаан бодох тухай өгүүлнэ.

Сэдэв 4. Зорилго, зорилт, үйл ажиллагааг хэмжих шалгуур үзүүлэлтийн чанар

Ногдох цаг: 1 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Өмнөх бодлогын зорилго, зорилт болон үйл ажиллагаа тэдгээрийн төлөвлөлтийн дагуу хэрэгжиж байгааг хэмжих шалгуур үзүүлэлтийн агуулгыг харьцуулж, шалгуур үзүүлэлтийн оновчтой, үр дүнд чиглэсэн байдлыг хэрхэн нягтлах тухай өгүүлнэ.

Сэдэв 5. Шалгуур үзүүлэлтийн найдвартай байдал

Ногдох цаг: 1 цаг

Хэлбэр: Кейс, ярилцлага

Сэдвийн агуулга: Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагааг хэмжих шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн найдвартай байдал, суурь болон хүрсэн түвшинг тодорхойлсон байдал хоёрын зөрүү, түүнийг шийдэх арга зүйн тухай тус тус өгүүлнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь /Төлөөлөгчдөд бүрэн эрхийн хугацааны эхэнд, Хурлын ажлын албаны ажилтнуудад шинээр томилогдмогц заах ба ИТХ-ын төлөөлөгчид болон Хурлын ажлын албаны ажилтнуудын орон нутгийн бодлогын төлөвлөлт, үнэлгээний талаарх ойлголтын зөрүүг арилгах, орон нутгийн хөгжлийг бодлогоор чиглүүлэх ур чадварыг эзэмшүүлэх/
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Кейс, ярилцлага, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:**

Энэ хичээлийг судлахын өмнө дараах хичээлийг бүрэн үзсэн байна. Үүнд:

- Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт
- Орон нутгийн салбар хоорондын бодлогын зохицуулалт

**“ОРОН НУТГИЙН БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ-II ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй - II”
- ✓ **Зорилго:** Бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтийн зөрүүнд шинжилгээ хийх, бодлогын хэрэгжилтийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн ИТХ-ын зүгээс ямар зохицуулалт хийх шаардлагатай байгааг нэгдсэн байдлаар олж харах чадвар эзэмшүүлэхэд оршино.
- ✓ **Зорилтот бүлэг:** Сонгогдсоноос 1-2 жилийн дараа нийт ИТХ-ын төлөөлөгчид, Хурлын ажлын албаны ажилтнуудад
- ✓ **Агуулга:** Уг хичээлийн агуулга нь сонгогдсоноос хойш ИТХ-ын төлөөлөгчдийн баталсан бодлогын баримт бичиг бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийх, үнэлэх, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зохицуулалтын хийх боломжийг олж харах чадварын дээшлүүлнэ.

Сэдэв 1. Батлагдсан бодлогын биелэлт ба үр дүнгийн танилцуулга

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, ярилцлага

Сэдвийн агуулга: Тухайн ИТХ-аар батлагдсан орон нутгийн бодлогын хэрэгжилт болон хүлээгдэж буй үр дүн хооронд үүссэн зөрүүг тодорхойлох, үр дүнг танилцуулах, харилцан санал солилцох, бодлогын хэрэгжилтэд үүссэн асуудлуудын тухай авч үзнэ.

Сэдэв 2. Бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ ба биелэлт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Бодлогын хэрэгжилтэд хийж байгаа хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн (зөвлөмж, түүний хэрэгжилт) болон нөхцөл байдал, ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албанд мэдээллийг цаг алдалгүй, үнэн зөв танилцуулж буй эсэх талаар авч үзнэ.

Сэдэв 3. Шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн алдаа ба анхаарах асуудал

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Тухайн ИТХ-аар батлагдсан бодлогын зорилго, зорилт болон үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжиж байгаа шалгуур үзүүлэлтийн бодит байдалд үүсч буй алдаа, түүний найдвартай байдлыг дээшлүүлэх шийдэл, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын тухай авч үзнэ

Сэдэв 4. Бодлогын оролцогч талуудын сонирхолын зөрчлийг шийдвэрлэх, зөвшилцөл

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийн зөрүү болон оролцогч талуудын ашиг сонирхол хоорондын хамаарал, нийтийн болон хувийн эрх ашгийн ялгаа ба давхцалын тухай авч үзнэ

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан түвшин /Батлагдсан бодлогын хэрэгжилтийн явцад Төлөөлөгчдөд, Хурлын ажлын албаны ажилтнуудын бодлогоор орон нутгийн хөгжлийг удирдан чиглүүлэх боломж, үр чадвар, нэгдмэл нэг бодлого, үзэл санааны талаарх ойлголтын зөрүүг багасгахад чиглэнэ.
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Кейс, ярилцлага, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:**
 - Урьдач нөхцөл: Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй-I хөтөлбөрт бүрэн хамрагдсан байх

**“ОРОН НУТГИЙН БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Орон нутгийн бодлогын үнэлгээ хийх арга зүй”
- ✓ **Зорилго:** Орон нутгийн бодлогын үнэлгээ хийх аргачлал, бодлогын үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулах мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, нарийн бичгийн дарга, хурлын ажлын албаны албан хаагчдад энэ сургалт зориулагдсан
- ✓ **Агуулга:** Бодлогын үнэлгээний талаарх ойлголт, Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл, аймаг нийслэлийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, сумын дүүргийн хөгжлийн төлөвлөгөөний үр дүнг үнэлэх арга хэрэгслийг хэрхэн ашиглах талаар ур чадвар эзэмшүүлнэ..

Сэдэв 1. Бодлогын үнэлгээний тухай ойлголт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, ярилцлага, багаар дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Бодлогын үнэлгээний талаарх ойлголт, мөн чанар, түүний ач холбогдол, чиг үүрэг, шалгуур үзүүлэлт, бодлогын үнэлгээний эрх зүйн орчин тайлбарлана. Бодлогын үнэлгээний тайланг үнэлэх аргачлалыг эзэмшүүлнэ.

Сэдэв 2. Бодлогын үнэлгээний аргууд

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, ярилцлага, багаар дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Бодлогын үнэлгээний хэлбэр, үнэлгээний үе шат, арга, аргачлалын талаар цэгцтэй мэдлэг эзэмшүүлнэ. Бодлогын үнэлгээний ажлын даалгавар боловсруулах ур чадвар эзэмшүүлнэ.

Сэдэв 3. Аймаг нийслэлийн дунд хугацааны бодлогын үнэлгээ

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, ярилцлага, багаар кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл, аймаг нийслэлийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг үнэлэх арга, аргачлалыг эзэмшүүлнэ

Сэдэв 4. Аймаг нийслэлийн богино хугацааны бодлогын үнэлгээ

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Кейс, лекц, ярилцлага, багаар кейс, дасгал ажиллах

Сэдвийн агуулга: Аймаг нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, сумын дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг үнэлэх арга, аргачлалыг эзэмшүүлнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Кейс, ярилцлага, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Төрийн бодлого хичээлийг урьдчилан үзсэн байх шаардлагатай.

**“ОРОН НУТГИЙН ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Орон нутгийн эрсдлийн үнэлгээ хийх арга зүй
- ✓ **Зорилго:** ИТХ-ын байгууллага, төлөөлөгчдийн орон нутагт чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч болох гадаад болон дотоод эрсдэл, түүний шалтгаан хүчин зүйлсийг тодорхойлох, үнэлэх, хариу үйлдлийг төлөвлөхөд шаардлагатай ур чадвар, цэгцтэй мэдлэгийг системтэй эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** Тухайн орон нутгийн ИТХ-ын дарга, төлөөлөгчид, нарийн бичгийн дарга, хурлын ажлын албаны албан хаагчдад
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Эрсдэлийг тодорхойлох: Орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг таньж мэдэх, тэдгээрээс үүсэх сөрөг үр дагавар, учир, шалтгааны хүчин зүйлс тодорхойлох.

Ногдох цаг: 4 цаг
Хэлбэр: Багшийн лекц, дасгал

Сэдэв 2. Эрсдэлийн үнэлэх: Орон нутгийн нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, түүний далайц, давтамжийг тодорхойлох.

Ногдох цаг: 2 цаг
Хэлбэр: Багшийн лекц, дасгал, кейс

Сэдэв 3. Эрсдэлийг даван туулах. Эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх арга, хэлбэрүүдийг тодорхойлох

Ногдох цаг: 2 цаг
Хэлбэр: Багшийн лекц, дасгал, кейс
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, семинар, ярилцлага, кейс дасгал ажиллах, багаар ажиллах, танин мэдэхүйн болон идэвхтэй оролцооны аргад тулгуурлан зохион байгуулна.
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Тус хичээлийн өмнөх шатанд Орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь, Орон нутгийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй, Орон нутгийн эдийн засгийн төлөвлөлт, Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага, Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүй Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй чиглэлээр зохих мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. Цаашид Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг хянах арга зүй, Ажлын гүйцэтгэлийг тайлагнах арга зүй, Өгөгдөл мэдээллийг орон нутгийн төлөвлөлтөд ашиглах арга зүй
Орон нутгийн бодлогын үнэлгээ хийх арга зүй зэрэг агуулга бүхий хичээлүүдийг гүнзгийрүүлэн үзнэ.

“ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МАНЛАЙЛАЛ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “ИТХ-ын төлөөлөгчийн манлайлал”
- ✓ **Зорилго:** ИТХ-ын төлөөлөгч нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд болон бусад төлөөлөгчдийг манлайлан ажиллахад шаардагдах онол, арга зүйн мэдлэгийг эзэмшиж, манлайлах чадвараа хөгжүүлэхэд оршино.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид
- ✓ **Агуулга:** Манлайлал: хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлал; Манлайллын хэв маяг, манлайлах арга барил; Төлөөлөгчийн хувийн манлайлал; Ёс зүйт манлайлал; Бусдыг үлгэрлэн манлайлах.

Сэдэв 1. Төлөөлөгч та манлайлагч

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал ажил, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: ИТХ-ын төлөөлөгчийн манлайлах хэрэгцээ, шаардлага. Манлайллын хөгжлийн чиг хандлагад тулгуурлан манлайллын хэв маяг, арга барилаа тодорхойлох арга.

Сэдэв 2. Төлөөлөгч та нөлөөлөгч

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал ажил, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Хувь хүний манлайлал, түүний ач холбогдол. ИТХ-ын төлөөлөгчид байх мэдлэг чадвар. Хувийн зохион байгуулалт, цаг төлөвлөлт, цагийн менежментийг хэрэгжүүлэх аргууд.

Сэдэв 3. Төлөөлөгч та ёс зүйгээр үлгэрлэгч

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, кейс, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Ёс зүйт манлайлал. Ёс зүйтэй болон ёс зүйгүй манлайлагчийн ялгаа. Төлөөлөгч ёс зүйтэй манлайллыг хэрэгжүүлэхийн ач холбогдол.

Сэдэв 4. Төлөөлөгч та оролцоог дэмжигч

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, кейс, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Баг бүрдүүлэх, багаар ажиллах. Багийн гишүүдийн хэв шинжийг тодорхойлох арга. ИТХ-ын төлөөлөгч байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллаж, оролцоог дэмжин манлайлахын ач холбогдол.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, хэлэлцүүлэг, дасгал, кейс ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг сургалтын хөтөлбөр нь ахисан түвшний “Та-манлайлагч” модуль бөгөөд “ИТХ-ын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт”, “Орон нутгий шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах нь”, “ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүй ба ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “ИТХ-ын төлөөлөгчийн имиж бүрдүүлэлт”, “Харилцааны ур чадвар”, “Өөрчлөлтийн удирдлага” зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.

“ГАДААД ХАРИЛЦАА, ДИПЛОМАТ ЁС” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Гадаад харилцаа, дипломат ёс
- ✓ **Зорилго:** Гадаад хамтын ажиллагааны арга хэмжээ төлөвлөх, түүнд оролцохдоо гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, дипломат ёс, протокол, этикетийг баримталж ажиллах мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Төрийн байгууллагын гадаад харилцаа, түүнд гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах зарчим, үйл ажиллагааг танилцуулах, төрийн байгууллага гадаад харилцаа, хамтын ажиллагааны аливаа үйл ажиллагаа зохион байгуулах, оролцохдоо анхаарах асуудлыг тайлбарлана.

Сэдэв 2. Дипломат ёс, протоколыг баримтлах

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, туршлага хуваалцах, дасгал

Сэдвийн агуулга: Гадаад харилцааны аливаа арга хэмжээ зохион байгуулах, оролцохдоо баримтлах дипломат ёс, протоколыг тайлбарлан таниулна.

Сэдэв 3. Төрийн ёслолын үйл ажиллагааны төрөл, ёслолын дэг

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал

Сэдвийн агуулга: Төрийн ёслолын үйл ажиллагааны төрөл, тэдгээрийн ялгаа, ёслолын үйл ажиллагаанд бэлдэх, оролцоход анхаарах асуудлыг тайлбарлан таниулна.

Сэдэв 4. Этикет

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал

Сэдвийн агуулга: Хувцаслалт, хооллолт, мэндлэх, зураг авхуулах, машин унаа хэрэглэх, бэлэг дурсгал өгөх зэрэг харилцаанд баримтлах дипломат ёсны нийтлэг хэм хэмжээг тайлбарлан таниулна.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь ахисан түвшний “Та-манлайлагч” модуль бөгөөд “Монгол Улсын төрийн бодлого, түүхэн уламжлал”, “ИТХ-ын ёс зүй”, “ИТХ-ын төлөөлөгчийн манлайлал” гэсэн хөтөлбөрүүдтэй уялдана.

“НИЙГЭМ БА ХҮН” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Нийгэм ба хүн
- ✓ **Зорилго:** Хүн нийгэмд биеэ авч явах байдал ба хүний зан үйл, мэдрэмж, бодол санаа зэрэг нь нийгэм дэхь бусад хүмүүст болон хүмүүс бусдадаа хэрхэн нөлөөлдгийг ойлгох анхны мэдлэгийг эзэмшихэд оршино.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албан хаагчид
- ✓ **Агуулга:** Нийгэм ба хүний талаарх ойлголтыг нийгмийн дүр, нийгмийн хүртэхүй, бүлэг, бүлэг дэхь зан төлөв, нийгмийн харилцан үйлчлэлийн энгийн түвшинд авч үзэх

Сэдэв 1. Нийгэм ба нийгмийн дүрүүд

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Хүн нийгэмд биеэ авч явах байдал, нийгмийн харилцаа, нийгмийн дүрүүдийн тухай тайлбарлах ярилцах

Сэдэв 2. Нийгмийн хүртэхүйн хэлбэрүүд

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, дасгал

Сэдвийн агуулга: Нийгмийн хүртэхүй гэж юуг хэлэх, түүний хэлбэрүүд, тэдгээрийн

онцлогийг тайлбарлах, холбогдох дасгал ажиллах

Сэдэв 3. Бүлэг, бүлгийн сэтгэл зүй

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: нийгэм дэхь бүлэг, бүлгийн үйл явцууд, бүлгийн онцлог, бүлэг дэхь зан төлөвийн талаар тайлбарлах ярилцах

Сэдэв 4. Нийгмийн харилцан үйлчлэл ба ИТХ-ын төлөөлөгч

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: лекц, дадлага

Сэдвийн агуулга: нийгмийн харилцан үйлчлэл гэж юуг хэлэх, ИТХ-ын төлөөлөгчийн нийгмийн дүр, нийгмийн дүрийн хүлээлтийн тухай тайлбарлах, ИТХ-ын төлөөлөгчдийн нийгмийн дүрийг бүтээх дадлага ажил хийлгэх

- ✓ **Танхимын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** лекц, ярилцлага, дасгал, дадалага
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа холбоо:**
 - ИТХ-ын төлөөлөгчийн имиж бүрдүүлэлт
 - Олон нийтийн харилцаа зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.

“УДИРДАХ ЭВ ДҮЙ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Удирдах эв дүй
- ✓ **Сургалтын зорилго:** “Дэмжих харилцаа” хандлагад тулгуурлан байгууллага, хамт олныг дирдан зохион байгуулах цогц ур чадварыг эзэмшүүлнэ
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1. Өөрийгөө таних, хянах үр чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Хувь хүн өөрийн онлог: темперамент, зан төлөв, үнэт зүйлс, хандлагын талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 2. Стрессийг даван туулах, урьдчилан хамгаалах ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Ажлын байранд стресс үүсгэх хүчин зүйлс, түүнийг таниж мэдэх, стресс үүсгэх хүчин зүйлсийг зохицуулах талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 3. Асуудлыг бүтээлчээр шийдэх ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Ажлын байранд стресс үүсгэх хүчин зүйлс, түүнийг таниж мэдэх, стресс үүсгэх хүчин зүйлсийг зохицуулах талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 4. Хүмүүсийн урам зоригийг бадраах ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Урам зоригт нөлөөлөх эерэг, сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлс, тэдгээрийг ялган таних, нийгэм сэтгэлзүйн болоод менежментийн арга ухаанаар зохицуулах талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 5. Багаар ажиллах сэтгэлгээг хөгжүүлэх ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Багаар ажиллахын давуу тал, багаар ажиллах явцад гарах нийгэм сэтгэлзүйн гаж нөлөөллүүд, тэдгээрийг таниж мэдэх, удирдлагын зүгээс хамтын сэтгэлгээг хөгжүүлэх арга замуудын талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 6. Зөрөлдөөнийг зохицуулах ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Ажлын байранд зөрөлдөөн үүсгэх хүчин зүйлс, тэдгээрийг зохицуулах сэтгэлзүйн болоод менежментийн арга замын талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 7. Эрх мэдэл, нөлөөгөө тэлэх ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** Эрх мэдэл, эрх мэдлийн төрлүүд, тэдгээрийн давуу сул талууд, бусдын эрх мэдлийн нөлөөг тэлэх арга ухааны талаар мэдлэг олгоно.
 - Сэдэв 8. Төлөөлүүлэн гүйцэтгүүлэх ур чадвар**
 - Ногдох цаг: 1 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдвийн агуулга:** төлөөлүүлэн гүйцэтгүүлэхийн мөн чанар, төлөөлүүлэн гүйцэтгүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, төлөөлүүлэн гүйцэтгүүлэх явцад эрх мэдлийг шилжүүлэх талаар мэдлэг олгоно.
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Ахисан түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Оролцооны арга, симуляцийн арга, дүрд тоглох арга, кейс дээр ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь ахисан түвшиний “Та-манлайлагч” модульд багтсан бөгөөд “Засаглал-иргэдийн оролцоо”, “Харилцааны ур чадвар”, “ИТХ-ын төлөөлөгчийн манлайлал” зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.